

БИЕ ХҮНИЙ СЭТГЭЛ ЗҮЙН ХЭВ ШИНЖИЙГ Г.АЙЗЕНКИЙН АСУУЛГААР СУДАЛСАН СУДАЛГААНЫ ЗАРИМ ҮР ДҮНГЭЭС

Ч.Отгонцэцэг, магистр, ӨМБИС

Abstract: Particularity of modern Mongolians has formed, varying during historic time. History-economic and social development and environment and ecological features influence to form a goodness of any countries, individual way of thinking and visualization. In this reason, Mongolians are greatly different from any other nations of the world. It is exactly true that nomadic cattle breeding and social and state organization which complied with it determine Mongolians way of thinking and psychological feature. The study has the importance by defining that the individuality of 25-65 aged Mongols differs from other nationalities in relations with their cultural difference, social attitude and historical background and etc. Furthermore no official studies have been conducted to reveal the psychological difference of 25-65 aged Mongols and it is believed that our current study will be followed by future studies on this topic. In this meaning, we tried to determine generic psychological character of Mongolians at the age of 25-65 using test in adult version to determine individual character, which was prepared by scientist H. Eysenck in 1975 in order to clarify Mongolians' psychological character and thinking cast. We involved 500 herders at the age of 25-65 in 5 areas including center, west, east, mountainous and fertile pastures and Ulaanbaatar in the research. From the preliminary result among participants in our research, Mongolian herders at the age of 25-65 are extrovert and introvert indicators E make is extrovert tended. N or neurotic make is well balanced. Also P or adaptable and inadapable make is well balanced. These makes have difference aleatory in part factors age, gender, region, education level and herds years.

Түлхүүр үг: бие хүний онцлог, экстраверт ба интроверт, сэтгэцийн үйлийн тэнцвэрт байдал, зан төрхийн эмгэгшил, психотизм

Удиртгал

Аль ч ард түмний үнэт зүйлс бүрэлдэж өөрийн гэсэн сэтгэлгээ, төсөөлөл бий болоход түүхэдийн засгийн болон нийгмийн хөгжил, байгаль-экологийн онцлог нөлөөлдөг байна. Энэ утгаараа монгол хүний сэтгэл зүйн онцлогт түүхэн замнал, соёлын ялгаа, нийгмийн тогтсон хандлага зэргээс хамаарч дэлхийн ямар ч үндэстэнээс ихээхэн ялгаатай нь мэдээж хэрэг. Нүүдлийн мал аж ахуй, түүнд зохицсон нийгэм-төрийн байгуулал нь Монголчуудын сэтгэлгээний онцлогийг тодорхойлсоор ирсэн юм. Бие хүний сэтгэл зүйн онцлогт сэтгэлийн хөдөлгөөн, оюун ухааны чадамж, зан үйлийн буюу харилцааны онцлог төлөвшил хандлагыг хамруулан ойлгож болох юм. Эрүүл саруул бие хүний сэтгэл зүйн асуудлыг судлах нь өрнө, дорны сэтгэл судлалын шинжлэх ухааны судлах гол асуудал хэдий ч нийгмийн хөгжил хурдацтай явагдаж буй өнөө үед насанд хүрсэн монгол бие хүний сэтгэл зүйн онцлогийг зайлшгүй танин мэдэж байх шаардлагатай юм.

Үндсэн хэсэг

Монгол хүний сэтгэл зүйн хэв шинжийг 25-65 насны малчин хүний жишээн дээр судалж

монгол бие хүний ерөнхий хэв шинжийг тодорхой хэмжээгээр тодорхойлох зорилго тавьлаа. Энэхүү судалгааны ажлын үндсийг Г.Айзенкийн бие хүний онол, судалгааны арга зүйд тулгуурласан Г. Айзенк нь өөрийн туршилт, тест, ажиглалтаар олж авсан ерөнхий бие хүний зан төлөвийн онцлогийн баримтын дүн шинжилгээнд тулгуурлан бие хүний зан төлөвийн бүтцийн шат дарааллын онолыг гаргаж ирсэн байна.

Г.Айзенк нь бие хүний зан төлөвийн бүтцийн хэв шинжийн онцлог шинж чанар, дадал зуршил, хариу үйлдэл, өвөрмөц хариу үйлдэл гэж дөрвөн төвшинд хувааж, дотоод гадаад хандлага, зан төрхийн өөрчлөлт, сэтгэцийн өөрчлөлт, оюуны чадавх, хуучныг баримтлагч чанар, радикализм гэсэн таван географикийг дэвшүүлсэн болно. Гэвч түүний дотоод, гадаад хандлага, зан төрхийн өөрчлөлт, сэтгэцийн өөрчлөлт нь бие хүний зан төлөвийн гурван үндсэн элемент юм. Түүний дотор сэтгэцийн өөрчлөлт нь бие даасан элемент болох ба нөгөө хоёр зан төрхийн өөрчлөлт, дотоод гадаад хандлагатайгаа холбоо хамааралгүй юм. Судлаач Ричард Рикмэн өөрийн “Рэн Гө Ли Лунь” бүтээлдээ “Г.Айзенк нь зан төрхийн өөрчлөлт

болон дотоод, гадаад хандлага гэх хоёр талаас нь бие хүний зан төлөвийн онцлог чанарыг дүрсэлнэ” гэж тайлбарласныг тусгасан байна (Ричард Рикмэн, 2005, х.186).

Мөн судлаач О. Мягмар “Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд” бүтээлдээ “Г.Айзенк зан үйлийн онцлогийг урьдчилан хэлэх нь сэтгэл судлалын шинжлэх ухааны зорилго байх ёстой. Мөн тэрээр хувь хүний зан үйлийн илрэлийг тайлбарлахад гурваас илүүгүй чухал онцлог чанарыг тодорхойлсон байх шаардлагатай хэмээн үзэж байсан төдийгүй бие хүний хөгжилд удамшлын хүчин зүйлийн гүйцэтгэх үүргийг түлхүү авч үзсэн” талаар тэмдэглэсэн байна (Мягмар, 2012, х.127).

Судалгааны арга зүй

Г.Айзенк өөрийн “Мануал оф дэ Айзенк персоналити” бүтээлдээ бие хүний зан төлөвийн тестийг 1975 онд боловсруулсан ба (EPQ) энэ нь түүний өмнө нь боловсруулж байсан зарим нэг зан төлөвийн тестээс санаа авч боловсруулагдсан. EPQ нь нэг төрлийн өөрийгөө сорих тест бөгөөд насанд хүрэгч, бага насны хүүхдийн гэсэн хоёр хувилбартай. E (дотоод гадаад хандлага), N (зан төрхийн өөрчлөлт), P (сэтгэцийн өөрчлөлт) болон L (дүр эсгэх эсвэл бүрэг ичимхий) гэсэн дөрвөн хэсгийг хамарсан байдаг талаар тайлбарласан байна. (Айзенк, 1996, х.96).

Бид энэхүү судалгаандаа судлаач Д.Эрдэнэчулуун (2010) “Хүүхдийг судлах арга зүй” бүтээлийн бие хүнийг судлах Айзенкийн 101 асуулгын насанд хүрэгчдийн хувилбарыг ашигласан (Эрдэнэчулуун, 2010, х.30). Асуулгын түүврийн мэдээллийн математик статистик

Судалгааны түүвэр ба хамрах хүрээ

Хүснэгт 1

Газар зүйн байршил болон хүйсийн харьцаа

Бүсээр	Хүйсээр Эрэгтэй	Эмэгтэй	Хүний тоо
Төвийн бүс	58	57	115
Баруун бүс	48	67	115
Зүүн бүс	58	57	115
Хангайн бүс	58	57	115
Улаанбаатар	20	20	40
Нийт	242	258	500

Судалгаанд оролцогчдын 48.4% нь эрэгтэй, 51.6% эмэгтэй, 92% нь хөдөө орон нутаг, 8% нь Улаанбаатар хотод харьяалагдаж байгаа нь дээрх хүснэгтээс харагдаж байна.

боловсруулалтыг Exel 2010, SPSS22.0 хийж гарсан тоо баримтыг Жөн Шүэ Жү Биэнь (2011) “Рэн Гө Шинь Ли Шүэ” бүтээлд тусгасан Айзенкийн бие хүний хэв шинжийн асуулгыг боловсруулах Т хувьд ($T=50+10(X-M)/SD$) шилжүүлэн үр дүнг гаргасан (Жөн Шүэ Жү Биэнь, 2011, х.58).

Уг тестийн баталгаа харьцангуй өндөр, үр дүн нь тоон статистик үйл хөдлөлийн ажиглалтаар батлагддаг учир ангаах ухаан, боловсрол, хууль зэрэг салбаруудад өргөн хэрэглэгддэг юм. 1980-аад оны эхэн үеэс улс орнуудад өргөн хэрэглэж эхэлсэн түүхтэй.

Г.Айзенкийн бие хүнийг судлах насанд хүрэгчдийн хувилбар бүхий энэхүү аргыг ашиглан хийгдсэн судалгаа Монголд одоогоор хийгдээгүй байгаа хэдий ч Р.Кеттеллийн бие хүний онцлогийг тодорхойлох судалгааны аргаар судлаач С.Оюунгэрэл (2012) “Бие хүний сэтгэл зүйн хувийн онцлогийг 16-18 насны монгол сурагчдын жишээн дээр” ахлах ангийн сурагчдын бие хүний сэтгэл зүйн онцлогийг судлан илрүүлэх зорилготойгоор судалсан байна.

Судалгааны үр дүн


Бид монгол бие хүний сэтгэл зүйн ерөнхий хэв шинжийн онцлогийг 25-65 насны монгол малчин хүний жишээн дээр Г.Айзенкийн EPQ насанд хүрэгчдийн хувилбараар тодруулах зорилготойгоор судалгааг явуулсан болно. Судалгаанд оролцогчдын ижил төстэй болон ялгаатай талууд тэдгээрийн онцлогийг бодитой тодорхойлохын тулд бүсүүдээс хүний тоог тэнцүү сонгосон юм. Нийт 5 бүсийн 500 хүнээс авсан судалгааны зарим үр дүнг танилцуулж байна.

Хүснэгт 2
Нас, хүйсийн үзүүлэлт

Нас	Эрэгтэй	Эмэгтэй	Нийт	Эзлэх хувь
25-45 нас	141	166	307	61.4
46-65 нас	101	92	193	38.6
Нийт	242	258	500	100

Дээрх хүснэгтээс харахад судалгаанд оролцогчдын 61.4%-ийг 25-45 насны, 38.6% -ийг 46-65 насны малчид эзэлж байна.

Диаграмм 1
Мал малласан жил



Судалгаанд хамрагдсан малчдыг мал малласан жилээр харьцуулан судалж үзэхэд 59.8% нь 1-15 жил мал малласан байна.

Харин 45-аас дээш жил мал маллаж байгаа ахмад малчид 1.6%-тай хамрагдсан болох нь дээрх диаграмм, хүснэгтээс харагдаж байна.

Хүснэгт 3
Боловсролын түвшин

Боловсролын түвшин	Хүний тоо	Эзлэх хувь
Боловсролгүй	12	2.4
Бага	36	7.2
Суурь	154	30.8
Бүрэн дунд	191	38.2
Техникум	29	5.8
Дээд	78	15.6
Нийт	500	100

Судалгаанд оролцогчдыг боловсролын төвшингөөр нь авч үзвэл боловсролгүй гэж хариулсан 2.4%, бага боловсролтой 7.2%, суурь боловсролтой 30.8%-ийг, бүрэн дунд боловсролтой 38.2%, техникумын боловсролтой малчид 5.8%-ийг эзэлж байгаа бол дээд боловсролтой малчид 15.6%-тай байна.

Судалгаанд Төв, Баруун, Зүүн, Хангай, Улаанбаатар 5 бүсийн нийт 500 малчин хамрагдсан бөгөөд судалгаанд оролцогчдын Е, N, P хэв шинжээр үр дүнг нэгтгэн үзэхэд:

Хүснэгт 4
25-65 насны малчин бие хүний Е, N, P хэв шинжийн ерөнхий байдал

Хувийн утга	Е	Хүний тоо	Хувь	N	Хүний тоо	Хувь	P	Хүний тоо	Хувь
T<38.5	Дотогш чиглэсэн	80	16%	Тогтвортой шинж	71	14.2%	Зохицох шинж	46	9.2%
38.5≤T<43.5	Дотогш хэлбийсэн хэлбэр	43	8.6%	Тогтвортой шинжид хэлбийсэн хэлбэр	60	12%	Зохицох шинжид хэлбийсэн хэлбэр	67	13.4%
43.5≤T<56.5	Дундаж	207	41.4%	Дундаж	243	48.6%	Дундаж	276	55.2%

56.5≤T<61.5	Гадагш хэлбийсэн хэлбэр	100	20%	Тогтворгүй шинжид хэлбийсэн хэлбэр	63	12.6%	Зохицолдохгүй шинжид хэлбийсэн хэлбэр	34	6.8%
T≥61.5	Гадагш чиглэсэн	70	14%	Тогтворгүй шинж	63	12.6%	Зохицолдохгүй шинж	77	15.4%

Дээрх хүснэгтээс харахад 25-65 насны монгол малчдын бие хүний E, N, P хэв шинжийн үзүүлэлт ерөнхийдөө (43-56.5) хооронд дундаж төвшинд илэрсэн байна. Эдгээрийг хэв шинж тус бүрээр авч үзвэл.

Харилцааны E хэв шинжийн тархалтаар дундаж хэв шинжтэй 207 хүн нь бүх хүний 41.4% буюу хамгийн өндөр хувийг эзэлж байна. Мөн гадагш хэлбийсэн болон гадагш чиглэсэн хэв шинжтэй 170 хүн нь бүх хүний 34%-ийг эзэлж байна. Дотогш болон дотогш хэлбийсэн хэв шинжтэй хүн 123 хүн нь бүх хүний 25% эзэлж байна.

Сэтгэцийн үйлийн N хэв шинжийн хувьд дундаж хэв шинжтэй 243 хүн нь бүх хүний 48.6% хамгийн өндөр хувийг эзэлж байна. Мөн тогтвортой шинжид хэлбийсэн болон тогтвортой хэв шинжтэй 131 хүн нь бүх хүний 26.2%-ийг эзэлж байна. Тогтворгүй шинжид хэлбийсэн болон тогтворгүй хэв шинжтэй 126 хүн нь бүх хүний 25.2% эзэлж байна.

Зан төрхийн эмгэгшил өөрчлөлт буюу психотизмын P хэв шинжийн хувьд дундаж шинжтэй 276 хүн нь бүх хүний 55.5% хувийг эзэлж байна. Мөн зохицолдомтгой болон зохицолдомтгой шинжид хэлбийсэн шинжтэй 113 хүн нь бүх хүний 22.6% эзэлж байна. Зохицолдохгүй шинжид хэлбийсэн болон зохицолдохгүй хэв шинжтэй 111 хүн нь бүх хүний 22.2% хувийг эзэлж байна.

E, N, P хэв шинжийг ерөнхийд нь авч үзвэл 25-65 насны монгол малчин бие хүн нь харилцааны E хэв шинжийн хувьд гадагш хэлбийсэн болон гадагш хэв шинжтэй байна. Сэтгэцийн үйлийн N хэв шинжийн хувьд тогтвортой болон тогтворгүй хэв шинж нь үндсэндээ тэнцвэртэй байна. Мөн зан төрхийн эмгэгшил өөрчлөлт буюу психотизмын P хувьд зохицолдомтгой болон зохицолдохгүй хэв шинж нь тэнцвэртэй байна.

Хүснэгт 5

Бие хүний хэв шинжийг насны шатан дахь тархалт. ($\bar{x} \pm S$)

Нас	E	N	P
25-45	50.0±10.0	50.3±9.9	50.7±10.4**
46-65	50.0±10.1	49.4±10.1	48.9±9.2**
F	0.015	0.466	7.214
P	0.903	0.903	0.007

Тайлбар: P<0.05*; P<0.01**

Хүснэгтээс харахад 25-65 насны бие хүний E, N, P хэв шинжийг насны байдлаар авч үзэхэд харилцааны E болон сэтгэцийн үйлийн N хэв шинжийн хувьд ялгаа илэрсэнгүй. Харин зан төрхийн эмгэгшил буюу психотизм P хэв шинжийн хувьд илэрхий ялгаатай байна (F=7.214, P=0.007<0.01). Энэ нь 46-65 насны бие хүний хэв шинж нь 25-45 насны бие хүний хэв шинжийг бодоход харьцангуй зохицолдох шинжид хэлбийсэн байдалтай байна.

Хүснэгт 6

Бие хүний хэв шинжийг хүйсээр ($\bar{x} \pm S$)

Хүйс	E	N	P
Эрэгтэй	49.9±9.6	49.4±10.7*	52.3±10.7**
Эмэгтэй	50.1±10.4	50.5±9.3*	47.8±8.8**
F	0.698	5.743	11.932
P	0.404	0.017	0.001

Тайлбар: P<0.05*; P<0.01**

Дээрх хүснэгтээс харахад 25-65 насны бие хүний E, N, P хэв шинжийг хүйсийн хувьд авч үзэхэд харилцааны E хэв шинжид эрэгтэй, эмэгтэй малчдын хооронд илэрхий ялгаа илэрсэнгүй. Харин сэтгэцийн үйлийн N хэв шинжийн хувьд эрэгтэйчүүдэд илэрсэн хувь нь эмэгтэйчүүдийн илэрсэн хувиас ялгаатай байна (F=5.743, P=0.017<0.05). Энэ нь эрэгтэйчүүдийг эмэгтэйчүүдтэй харьцуулахад тогтвортой хэв шинжид хэлбийсэн онцлогтой байна. Зан төрхийн эмгэгшил өөрчлөлт буюу психотизмын P хэв шинжийн хувьд эрэгтэйчүүдийн илэрсэн хувь нь эмэгтэйчүүдийн илэрсэн хувиас илэрхий ялгаатай байна. Энэ нь эрэгтэйчүүдийг эмэгтэйчүүдтэй харьцуулахад эрэгтэйчүүд харьцангуй зохицолдохгүй хэв шинжид хэлбийсэн онцлогтой байдаг байна.

ДҮГНЭЛТ

Энэхүү Г.Айзенкийн судалгааг явуулсны эцэст дараах дүгнэлтийг хийж болохоор байна.

1. 25-65 насны монгол малчин бие хүн нь харилцааны хувьд гадагш хэлбийсэн хэв шинжтэй. Сэтгэцийн үйлийн хувьд үндсэндээ тогтвортой, зан төрхийн өөрчлөлт буюу психотизмын хувьд зохицолдомтгой болон зохицолдохгүй хэв шинж нь тэнцвэртэй байна. Эдгээр хэв шинж нь нас, хүйс, амьдарч буй бүс, боловсролын төвшингөөс хамаарч зарим талаараа ялгаатай байна. Үүнээс зарим үр дүнг авч үзэхэд: Хүйсийн хувьд сэтгэцийн үйлийн N хэв шинжийн ялгаатай байдал нь эрэгтэйчүүдийг эмэгтэйчүүдтэй харьцуулахад харьцангуй тууштай туйлбартай, дөлгөөн тогтуун амгалан тайван хэв шинжийн онцлогтой байна. Харин эмэгтэйчүүд сэтгэл санаа гэгэлзэн тогтворгүй болж сэтгэл санааны байдал амархан солигдох, сэтгэл зовинох, айж түгшиж анхаарал сулрах, стрессийн нөхцөл байдалд барьц алдаж амархан уурлаж бухимдах зэрэг хэв шинжийн онцлогтой байна. Зан төрх буюу психотизмын хувьд эрэгтэйчүүд харьцангуй зохицолдохгүй хэв шинжид хэлбийсэн догшин, түрэмгий, зөрж зөрчилдөх сөргөлдөх хандлага илүү байдаг байна. Насны хувьд 46-65 насны малчдын бие хүний хэв шинж нь 25-45 насны малчдын бие хүний хэв шинжийг бодоход тогтвортой аливаа зүйлд бодитой ханддаг, уян зөөлөн харьцангуй зохицолдох шинжид хэлбийсэн онцлогтой байна.
2. 25-65 насны монгол бие хүний сэтгэл зүйн онцлогийг илрүүлэх албан ёсны судалгаа одоогоор хийгдээгүй байгаа боловч бидний энэхүү судалгаа нь дараа дараагийн судалгааны эхлэлийг тавьж байгаагаараа онцлог юм.
3. Судалгааны үр дүнд монгол хүний төдийгүй тэр дундаа бидний онцгойлон авч үзсэн малчин хүнд чиглэсэн үйлчилгээг хөгжүүлэх сургалт, төсөл хөтөлбөрийг боловсруулахад, мөн сэтгэл зүйн зөвлөгөө болон сэтгэц заслын практикт ашиглах боломжтой гэж үзэж байна.
4. Дээрх бие хүний сэтгэл зүйн ерөнхий хэв шинжээр гарч буй үр дүнг дэлгэрүүлэн судлах зорилгоор Р.Кеттелл (16PF)-ийн бие

хүний сэтгэл зүйн онцлогийг тодорхойлох тестээр судалгаа авч боловсруулалт хийж байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Мягмар, О. (2012). *Хүний хөгжлийн сэтгэл зүйн лекцүүд*. Улаанбаатар: Ган принт
- Оюунгэрэл, С. (2012). Бие хүний сэтгэл зүйн хувийн онцлогийг судалсан нь. *Сэтгэл судлалын ухааны докторын зэрэг горилсон нэг сэдэвт зохиол*. Улаанбаатар.
- Эрдэнэчулуун, Д. (2010). Хүүхдийг судлах арга зүй. хоёрдугаар дэвтэр. Улаанбаатар: Ган принт
- Eysenck, H. (1996). *Manual of the Eysenck Personality*. London: Hodder&Stoughton Publishers.
- 人格心理学/□雪主□. (2011.9重印). □南大学出版社.
- Richard M. Ryckman. (2005). 著; 高峰□等□ “人格理□” 第八版□西□范大学出版社.